

## 2

### МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ, ХЭТИЙН ТӨЛВИЙН СУДАЛГАА

#### 3.Отгон

##### ОРШИЛ

Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйл хэргийн салшгүй хэсэг нь Эм хангамж үйлдвэрлэл, үйлчилгээний алба юм.

Монгол улсын эмийн үндэсний бодлого, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд дотоодын эмийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаанаас ихээхэн хамаарах болно.

Сүүлийн 3 жилийн судалгаагаар манай улсын эмнэлэг, хүн амын хэрэглэж байгаа улсын бүртгэлтэй эмийн нийт нэр төрлийн 30-35%, нэг жилийн эмийн хэрэглээний 40%, ҮЗШЭ-ийн нэр төрлийн 40 гаруй хувийг дотоодын эмийн үйлдвэрээр хангаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 68-р тогтоолын 4-д эмийн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, зайлшгүй шаардлагатай эмийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай тодорхой заасан байдаг.

1990 оноос хойш бий болсон эмийн үйлдвэрүүд нь зөвхөн хувийн өмчийн эзний санал санаачлагаар банкны зээлээр санхүүжин төрийн бодлогоор эдийн засгийн талаас бодитой дэмжлэг авч чадаагүй байгаа юм.

Манайд эмийн үйлдвэрлэл, хангамж үйлчилгээний салбарын хууль эрх зүйн орчин харьцангуй тогтворжиж хэрэгжих шатандаа ороод байгаа бөгөөд өнөөгийн нөхцөлд шударга өрсөлдөөн чанартай бүтээгдэхүүн бидний ажлын гол үзүүлэлт юм.

##### Судалгааны үндэслэл

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болсон эмийн үндэсний бодлого, хууль, стандартыг бүрэн хэрэгжүүлэхэд дотоодын эмийн үйлдвэрийн техник технологийг улам боловсронгуй болгож бүтээгдэхүүгийн чанарыг сайжруулахад байнга анхаарч хүч хөрөнгө гаргах хэрэгтэй байгаа юм.

Монгол улсад эмийн үйлдвэрлэл үүсч хөгжсөн 80-н жилийн түүхэн замналаа эргэн харж, ололт, дутагдалдаа дүгнэлт хийж үндэсний эмийн үйлдвэрлэлийн техник, технологи, стандартыг сайжруулан, бүтээгдэхүүгийн чанар, нэр төрлийг нэмэгдүүлэх асуудалд энэхүү судалгаа нь зохих үндэслэл болно гэж судлаач би үзэж байна.

### **Зорилго**

Монгол улсад Үндэсний эмийн үйлдвэрлэл үүсч хөгжсөн түүхэн замналыг судлан хэтийн төлөв, чиглэл тогтоох.

### **Зорилт**

- Эмийн үйлдвэрлэлийн үүсэл хөгжлийн түвшинг түүхэн тодорхой үе шатаар авч үзэх
- Эрүүл мэндийн үйлчилгээнд зориулсан Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж төхөөрөмжийн үйлдвэрлэлийн зориулалтыг тогтоох
- Нийгэм, эдийн засгийн харилцаа, өмчийн хэлбэртэй холбоотой эмийн үйлдвэрлэлийн байдалд дүгнэлт хийх
- Үндэсний эмийн үйлдвэрийн түүх замналыг судлах
- Цаашдын чиглэл хандлагын талаар санал дэвшүүлэх

### **Судалгааны шинэлэг тал, ач холбогдол**

- Үндэсний эмийн үйлдвэрлэлийг түүхэн ба өнөөгийн болон ирээдүй талаас нь судалж авч үзсэн ямар нэг бүтээл хараахан хийгдээгүй.
- Монгол улсын Засгийн газраас сүүлийн жилүүдэд үндэсний үйлдвэрийг хөгжүүлэх талаар үе шаттай бодлого дэвшүүлж энэ чиглэлд анхаарч байгаа.
- ҮЗШЭ-ийн нэр төрөлд дотоодын эмийн бүтээгдэхүүгийн нэмэгдүүлэх, ялангуяа импортын бүтээгдэхүүгийн орлох үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүгийн үйлдвэрлэлийг хуулиар дэмжиж байгаа. Ийм үед энэхүү судалгаа нь бодит үндэслэл болох юм. Үүнд:
  - Зах зээлийн үед эмийн үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл тогтоох
  - Үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ дагнах, хорших
  - Шинэ зах зээл олох боломж, чиглэл гаргах
  - Үндэсний бодлого чиглэл тодорхойлоход ашиглах

### **Судалгааны материал ба арга зүй**

Архивын материал, эмийн үйлдвэрийн түүхэн товчоог холбогдох хэвлэлийн материалаас түүвэрлэн харьцуулалт хийх, тоон болон утга агуулгын үзүүлэлтээр ялган нэгтгэх, асуулт судалгаа авах, ахмад хүмүүс, мэргэшсэн ажилчдаас мэдээлэл цуглуулах зэрэг аргуудыг сонгон хэрэглэв.

Цуглуулсан материалыг /windows xp-ын word, excel, / программууд болон график, зураглалын аргуудыг ашиглан хийв.

## Судалгааны үр дүн

Монгол улсад Үндэсний эмийн үйлдвэр үүсч хөгжсөн түүхэн үеийг судалж үзэхэд дараах 3 үе болгон авч үзэж болох юм.

**1-р үе.** Ардын хувьсгал ялсны дараах үе буюу үндэсний эмийн үйлдвэрлэлийн суурь тавигдаж эхэлсэн үе. 1930-1940 он

**2-р үе.** Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үе буюу техник, технологи нэвтэрч үйлдвэрлэл жигдрэх үе. 1940-1990 он

**3-р үе.** Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үе буюу Хувийн хэвшлийн үйлдвэрлэл үүсч хөгжих үе. 1990-2010 он

### I үе:

1923 оны 10 сарын 25-нд цэргийн эмнэлгийн дэргэд анхны эмийн сан байгуулагдсанаар хүн амыг эм хэрэглэлээр үйлчлэх мэргэжлийн байгууллагын суурь тавигджээ.

Анхны эмийн санг түшиглүүлэн 1929 онд эмийг хэрэгцээнд тохируулан бэлтгэх тасаг нээж, улмаар 1930 онд эм бэлдэх лаборатори болгосноор Монгол оронд эм үйлдвэрлэх анхны алхам болжээ. Энэ тасаг нь эхний үед захиалгаар нунтаг эмүүдийг дангаар нь буюу хольж найруулан гар жингээр тугнан боох, жижиглэн савлах ажиллагааг гүйцэтгэж байв.

1934 онд эм бэлтгэх тасгийн хүчин чадлыг нэмэгдүүлэн эм үйлдвэрлэх галены лаборатори болгон орон тоог 22 нэгж хүртэл нэмэгдүүлсэн байна.

### II үе:

1955 онд улсын эм үйлдвэрлэх заводыг ашиглалтанд оруулан таван жилийн эцэст эм үйлдвэрлэлийг барагцаалахад 4,2 дахин нэмэгдүүлэхийг зааж, улмаар эм үйлдвэрлэх галены лабораторийг өргөтгөн 1958 онд ашиглалтанд оруулж, ЗХУ, БНУАУ, БНАГУ-ын машин, тоног төхөөрөмжөөр тоноглож, шахмал, тун шилтэй тарилга, галений бэлдмэл бэлтгэх үндсэн тасгууд болон уур ус, хэвлэл хайрцаг, механик засвар зэрэг үйлдвэрлэлийн туслах цех тасагтайгаар жилд 6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслийн хүчин чадалтай анхны эмийн завод байгуулагдсан болно.

Мөн 1959 оны 67 дугаар тогтоолоор Эмийн заводыг өргөтгөж бие даасан аж ахуйн тооцоотой үйлдвэр болгожээ.

Тус эмийн завод III таван жилд

- Шахмал эм 7,4 сая боодол
- Тун шилтэй тарилга 2,0 сая ширхэг
- Төрөл бүрийн хандмал эм 42 тн
- Тосон эм 12 тн
- Ороох боох материал 1,5 сая метр
- Төрөл бүрийн витамин 28 тн зэрэг 92 нэр төрлийн 5 сая төгрөгний эм барааг үйлдвэрлэж байжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1965 оны 90 дүгээр тогтоолоор “Эм шалгах төв лабораторийг ” байгуулснаар эм биобэлдмэлийн улсын хяналтын системийн суурь тавигдажээ.

Эмийн заводод механикжилтыг нэвтрүүлэх, шинэ технологийг эзэмших зорилгоор тус заводын дэргэд 1966 онд “Зохион бүтээх лаборатори” байгуулагджээ.

ДЭМБ-ын тусламжаар жил тутам 100 тонн нөхөн сэлбэх, төрөл бүрийн тарилгын шингэнийг үйлдвэрлэх шинэ тасгийг 1974 онд ашиглалтанд оруулсан явдал нь эмчилгээний зориулалтаар чухал бэлдмэлүүдийг өргөн хэрэглэх боломжийг үлэмж нэмэгдүүлэв.

IV таван жилд бүтээгдэхүүгийн үйлдвэрлэл /1970 онд 1965 оныхоос/ 17,9% өсөж, хөдөлмөрийн бүтээмж 18,4%, ашигт ажиллагааны түвшин 4,4% дээшилж, бүтээгдэхүүгийн өөрийн өртөг 0,1 мөнгөөр хямдарчээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1969 оны 309 дүгээр тогтоолоор Эмийн ургамал бэлтгэх конторыг аж ахуйн тооцоон дээр байгуулж, ургамлын түүхий эдийг экспортын хэрэгцээнд гаргах ажлыг эхлүүлснээр УЭЭУ-ын компанийн суурь тавигдсан юм.

Эмийн ургамлыг угаах, жижиглэх, хэрчих, нунтаглах, хатаах, савлах технологи үйл ажиллагаатай өндөр хүчин чадалтай анхан шатны боловсруулалт хийх цех ашиглалтанд оруулснаар Болгар, Хятад, Вьетнам, Солонгос зэрэг улсуудад чихэр өвс, хунчир, зээргэнэ, алтан гагнуур зэрэг 300 тн эмийн ургамлын түүхий эд экспортолж байжээ.

1969 онд УЭХҮГ-ын харьяанд “Эмнэлгийн багаж төхөөрөмжийн засвар угсралтын тасаг”-ыг аж ахуйн тооцоон дээр ажиллуулахаар зохион байгуулжээ.

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1973 оны 253-р тогтоолоор ЭАХНСУ-ын институтээс биобэлдмэлийн хэсгийг салгаж, ажил төрлийн чиг, үйлдвэр шинжилгээний ажиллагааны онцлог байдлыг харгалзан төвлөрүүлэх зорилгоор цус сэлбэх төв станцтай нэгтгэж, Биобэлдмэл цусны үйлдвэр шинжилгээний институтыг байгуулав.

Гэвч урьд өмнө нь 1933 онд манай оронд анх үйлдвэрлэсэн цагаан цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинаас эхлээд орчин үеийн өргөн хэрэгцээт иммуноглобулин, альбумин, онош зүйн бодис хүртэл олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж, эрүүлийг хамгаалахын тухайн үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн түүхтэй.

1939 онд Халх голын дайны үед фронтод шархтсан цэргүүдэд цэргийн алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн хүмүүс, ард иргэд цусаа өгч туслаж байсан тэр үеэс эхэлсэн бөгөөд мэс заслын эмнэлгийн дэргэд 1956 онд жилд 50 литр цус бэлтгэх хүчин чадалтай цус сэлбэх анхны станц байгуулснаар донорын цус, цусан эмчилгээг хэрэглэх явдал жилээс жилд өссөөр байна.

АУХ-гийн дэргэд эмзүйн сектор 1972 онд байгуулснаар эм зүйн шинжлэх ухааны тулгын чулууг тавьжээ.

Байгалийн нэгдлийн хүрээлэнтэй хамтран мал эмнэлгийн зориулалтын бүтээгдэхүүн үйлдвэрлэх биоцехийг ашиглалтанд оруулан, уурагжсан тэжээл, тэжээлийн окситетрациклин үйлдвэрлэв.

Хөвсгөл, Завхан аймгийн ЭСУК-ын дэргэд эмийн ургамал бэлтгэлийн тасаг нээжээ.

СнЗ-ийн 1972 оны 57-р тогтоолоор УЭХҮГ-ын харьяанд аж ахуйн тооцоон дээр ажиллах Нүдний шилний үйлдвэрийг байгуулж, улмаар бүх аймаг хотод салбартай болжээ.

1985 он гэхэд Эмийн үйлдвэр жилдээ 15,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж бүх бүтээгдэхүүн нь улсын стандарт технологийн заавартай, чанарын баталгаатай болж тус үйлдвэрийн 4 цехийн 70 гаруй хувьд автоматжуулалт механикжуулалт нэвтэрсэн байжээ.

Монголчууд 1921 оны ардын хувьсгалаас өмнөх хүртэл Энэтхэгийн Аюурведийн угсаатай Төвдөөр дамжин уламжлагдаж ирсэн уламжлалт анагаах ухааныг ард түмнийхээ буй болгосон эмчилгээ, заслын арга барилаар баяжуулж хэрэглэж ирсэн түүхтэй.

Манай оронд өвчнийг анагаах чадвартай биологийн идэвхт бодис агуулсан 70 гаруй 700 орчим нэрийн эмийн ургамал ургадаг талаар манай эрдэмтэн судлаачид тогтоосон байна. Уг судалгаагаар эртнээс монгол оточ нарын эмчилгээнд хэрэглэж байсан жор давхардсан тоогоор 11000 орчим байсныг бүртгэж, эмчилгээнд зайлшгүй шаардлагатай 200-аад эмийн жорыг ялган авч түүний найрлагад ордог эмийн ургамал, амьтны эд эрхтэн, эрдсийн гаралтай түүхий эдийн орц давтамжийг судлаачид тогтоожээ.

### **Ш үе:**


1990 оноос эхлэн улс төрд ардчилал, эдийн засагт зах зээлийн харилцаа нэвтэрснээр эм хангамжийн төвлөрсөн систем задарч хувийн өмчийн эмийн сан, эмийн үйлдвэр /Монос, Монг-эм, Манбадацан гэх мэт/ байгуулагдаж эхлэв.

1991 оноос ДЭМБ-тай хамтран Үндэсний эмийн бодлогын 4 удаагийн бага хурал хийж “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эмийн тухай” хууль гаргах үндэс суурийг тавьснаар ДЭМБ-ын Үндэсний эмийн бодлоготой орны тоонд багтан орлоо.

Монгол улсын эмийн үйлдвэрлэл түүхэндээ 60 жилд нь социалист тогтолцоо буюу төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн аргаар хөгжиж, 20 жилд зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийн тогтолцоонд ороод 80 жилийн түүхэн замналыг туулж явна.


Энэ үед үүсч бий болсон үйлдвэрүүдийн хугацаа, өмчийн хэлбэр, үйлдвэрлэлийг төрөл чиглэлээр харьцуулан авч үзвэл:

Зураг №1




Зургаас харахад одоогоор мэргэжлийн эрх зөвшөөрөлтэй ажиллаж байгаа эмийн үйлдвэрүүдийн 84,6% нь 1990 оноос хойш буюу судалгааны III үед байгуулагдсан бөгөөд төрийн болон хамтарсан өмчийн хэлбэртэй үйлдвэрүүд I, II үед хамрагдаж байна.

Зураг №2



Энэ нь улс төр, эдийн засгийн эрх чөлөөний давуу талыг бодитой харуулж байгаа нэг үзүүлэлт юм. Гэвч мэргэжлийн үйл ажиллагааны онцлог ёс зүйг анхаарахгүй орхигдсон тал бий.

Зураг №3



- I Орчин үеийн буюу Европ эмийн -22
- II Уламжлалт эмийн -8
- III Эмнэлгийн хэрэгслийн-3
- IV Цус биобэлдмэлийн -4
- V Ариутгал, халдваргүйжилтийн -1

Зураг №3-аас харахад орчин үеийн буюу Европ эмийн үйлдвэрүүд дийлэнх хувийг эзэлж байна. Гэтэл эмчилгээ, оношлогоо, урьдчилан сэргийлэлтийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл маш цөөн байгаа нь зах зээлийг дагасан, бүтээгдэхүүгийн давхардал ихтэй үйлдвэрүүд олон байгаа нь цаашид хүн амын эрүүл мэндийн асуудалд илүү анхааран тэгш бодлого үгүйлэгдэж байгааг дурьдах нь зүйтэй юм.

Зураг №4



Зургаас харахад 40-өөс дээш жил болсон үйлдвэрүүд нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед байгуулагдсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүд

байна. Харин сүүлийн 5 жилд бий болсон голдуу тарилгын зориулалттай шингэн эм болон антибиотик эмийн чиглэлийн үйлдвэрүүд нь техник технологийн хувьд илүү сайн болж чанарын шаардлага хангах хэмжээнд ажиллаж байгаа нь үндэсний эмийн үйлдвэрийн ирээдүйг харуулж байгаа үзүүлэлт гэж үзэж байна.

1990 онд эмийн үйлдвэр, цусны төв, биобэлдмэлийн төв, Мон-Энзим зэрэг 5 үйлдвэр ажиллаж байсан бол өнөөгийн байдлаар орчин үеийн буюу европ эмийн үйлдвэр 25, уламжлалт эмийн үйлдвэр 6, эмнэлгийн хэрэгсэл нэг удаагийн тариур, ороох боох материалын үйлдвэр 3, цус биобэлдмэл, ферментийн 4, ариутгал халдваргүйтэлийн 1 нийт 38 үйлдвэртэй болж тэдгээрт 1200 гаруй хүн ажиллаж байгаагийн 250 /35%/ нь эм зүйч, эм найруулагч, химич, уламжлалт эмчилгээний эмч, биотехнологч, биологич, бактерлогч, вирусологч, биохимич, иммунологч, инженер, эрүүл ахуйч эмч нар ажиллаж байна. Ийнхүү сүүлийн 14 жилд эмийн үйлдвэрийн тоо 7 дахин, ажиллагсдын тоо 6 дахин өсч, өнөөдөр улсын өмчийн 5 /13,8%/, хувийн өмчийн 33 /86,2%/ үйлдвэр ажиллаж байна.

2010 онд 10 орчим тэрбум төгрөгийн эм, биобэлдмэл, ороох боох хэрэгсэл, зүү тариур үйлдвэрлэсэн нь 1997 оныхоос 60%-иар өссөн буюу жилийн дундаж өсөлт 25% байна. Өсөлтийн ийм өндөр хурдтай эх орны үйлдвэрлэлийн салбар цөөхөн байгааг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

1989 онд эх орны эмийн үйлдвэр улсын эмийн нийт хэрэгцээний 10 орчим хувийг, 1997 онд 24,3%-ийг үйлдвэрлэж байсан бол 2010 оны эхний хагас жилийн байдлаар 40 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Эмийн үйлдвэрлэлийн салбарт 1997 онд 531 хүн ажиллаж байсан бол одоо 1200 гаруй хүн ажиллаж нийт ажиллагсдын тоо 65%-иар нэмэгдлээ.

Үйлдвэрлэж буй эмүүдийг нэр төрөл, хэлбэрээр авч үзвэл: 37% нь шахмал эм, 15% нь тарилгын уусмал, 9% нь үрэл, 1% нь тосон түрхэц, 28% нь галены бэлдмэл, 2% нь антибиотик, 7% нь зэхмэл, 1% нь эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал эзэлж байна.

Эм холбооноос эх орны эмийн дотоодын зах зээлээ хамгаалж эх орондоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүгийн хэрэгцээг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, хөгжүүлэх зорилгоор импортын эмийн хэмжээг бууруулан үндэсний үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүгийн чанарыг сайжруулах, улмаар дэлхийн түвшинд хүргэх бодлого баримталж байна.

Үндэсний эмийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүгийн дотоодын зах зээлийн борлуулалтыг дэмжихийн тулд ижил нэрийн эмийн импортын асуудлыг төрийн бодлогоор зохицуулбал үндэсний чанартай эмийн бүтээгдэхүүгийн хэрэглээ өсч, импортыг бууруулснаар дотоодын нийт бүтээгдэхүүгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд тодорхой дэм болох юм.

XXI зуун бол амьтан, ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүгийн зуун болох нь нэгэнт тодорхой боллоо. Эх орны амьтан, ургамал, эрдсийн гаралтай түүхий эд, олон мянган жилийн түүхтэй уламжлалт анагаах ухааны жорыг уйгагүй судлах цаг болжээ.



Одоо дэлхий даяар химийн гаралтай эмийн хэрэглээ жилд 2-3%-иар өсч байхад байгалийн түүхий эдээр хийсэн эмийн хэрэглээ жилд 5-8% иар өсч байна.

#### **Дүгнэлт**

1. 2010 оны эхний судалгаанаас үзэхэд сүүлийн 3-н жилд дунджаар үндэсний эмийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн жилд 8-10 нэр төрлөөр нэмэгдэж, улсын бүртгэлтэй нийт эмэнд 30-35%, ҮЗШЭ-ийн 35%-ийг эзэлж байна.
2. Манайд ажиллаж байгаа эрх зөвшөөрөлтэй эмийн үйлдвэрүүдийн 6% нь төрийн, 84% нь хувийн хэвшлийн өмчтэй байгаа нь цаашид төрийн бодлого, эдийн засгийн зохицуулалтыг зөв хийх үндэслэл ажиглагдаж байна.
3. Зах зээлийн нөхцөлд эмийн чанар аюулгүй байдлын үүднээс үндэсний үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй инновацижуулан хөгжүүлэх цогц бодлого, шинэ менежмент хийх цаг болсныг энэхүү судалгаа харуулж байна.

#### **Дэвшүүлж буй санал**

- Үндэсний эмийн үйлдвэрлэлийг 2005-2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл бодлогыг боловсруулан батлуулан хэрэгжүүлэх, үндэсний концепц GMP буюу УСТ-ийг нэвтрүүлэхэд төлөвлөгөөтэй ажиллан, эмийн үйлдвэрлэлийн чанарт түүхий эд хүлээж авахаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн хүртэл дамжлагын болон хими, биологийн шинжилгээний хяналтыг хүчтэй болгох, бүтээгдэхүүгийн чанарыг дээшлүүлэх, өнгө үзэмж, сав баглаа боодлыг сайжруулах, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин үеийн тоног төхөөрөмжөөр лабораториудыг тоноглох.
- Эмийн үйлдвэрлэлд ажиллаж буй бүх шатны ажиллагсдын эм зүйн болон зах зээлийн эдийн засаг, маркетинг, менежментийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх
- Эмийн үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэх, байгалийн гаралтай түүхий эдээр шинэ эм үйлдвэрлэхэд эрдэм шинжилгээ, тоног төхөөрөмж, боловсон хүчний хүч чадлыг төвлөрүүлэх, сироп, бүрмэл шахмал, уусдаг шахмал, лаа зэрэг орчин үеийн эмийн хэлбэрүүдийг үйлдвэрлэлд шинээр нэвтрүүлэх
- Байгалийн гаралтай эмээр олон улсын зах зээлд өрсөлдөх чиглэл баримтлах, эмийн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, дагнах, хорших

чиглэлээр эмийн үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн инновацийг нэвтэрүүлэх

- Шинэ эм зохион бүтээх, эмийн чанарыг дээшлүүлэх дэвшилтэт технологи боловсруулах талаар эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, төвлөрүүлэх, экспортын чиглэлтэй эм зохион бүтээхэд гол анхаарлаа хандуулах зэрэг зорилтуудыг дэвшүүлж байна.
- Эмийн үйлдвэрлэл нь ихээхэн хөрөнгө оруулалт, өндөр технологи, тоног төхөөрөмж шаарддаг бөгөөд эх орны эмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа дутагдаж байна. Эмийн үйлдвэрлэл ялангуяа биотехнологийн чиглэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг анхаарч Монгол улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлд багтаах, шинжлэх ухаан, технологийн парк, инкубаторт хамруулах талаар идэвхтэй ажиллахыг төр засагт уриалж байна.
- Орчин үеийн эмийн үйлдвэрлэлийн техник технологийг эзэмшиж нэвтрүүлснээр бүтээгдэхүүгийн нэр төрлийг олшруулах, ҮЗШЭ-ийн жагсаалтанд орсон эмийг шинээр үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд онцгой анхаарч энэ талаар бодлогын чанартай арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- ҮЗШЭ-ийн жагсаалтанд орсон эмийг үйлдвэрлэх, импортлох, хангахад нэмүү өртгийн татвараас чөлөөлүүлэх, ашгийн татварыг хөнгөлөх, шинэ техник тоног төхөөрөмж оруулж ирэхэд татвараас бүрэн чөлөөлөх
- Уламжлалт эмийн чанарын хяналтын системийг төгөлдөржүүлэх, уламжлалт эмийн түүхий эдийн стандартыг боловсруулах ажлыг зохион байгуулах

#### Хавсралт-1

1. Эмийн үйлдвэр ХХК	1930 он	80 жил
2. Моносфарм ХХК	1990 он	20 жил
3. Нахиа фарм ХХК	1994 он	16 жил
4. Гамба ХХК	1996 он	14 жил
5. Отгоннаст ХХК	1998 он	12 жил
6. Эрдэнэ бүрэн фарм	1998 он	12 жил
7. Ариун монгол ХХК	1992 он	18 жил
8. Эв-Эрдэнэ ХХК	1993 он	17 жил
9. Аньс фарм ХХК	1994 он	16 жил
10. Тавин-Ус ХХК	2003 он	7 жил
11. Монадонис ХХК	1999 он	11 жил
12. Мон-Энзим ХХК	1976 он	34 жил
13. Шинэбат ХХК	1995 он	15 жил
14. Биотехнологийн үйлдвэр	1932 он	78 жил
15. Цусны төв	1962 он	48 жил

16. Манбадацан	1990 он	20 жил
17. Монг-Эм ХХК	1990 он	20 жил
18. Элэг судлалын төв	1989 он	21 жил
19. Монсам ХХК	1995 он	15 жил
20. Цомбо ХХК	2005 он	5 жил
21. Астрафарм ХХК	2002 он	8 жил
22. Айвико ХХК	2005 он	5 жил
23. Алтангэр фарм	2006 он	4 жил
24. Тун фарм ХХК	2007 он	3 жил
25. УЭЭУ-ын компани	1969 он	41 жил
26. УАШУТУК	1973 он	37 жил
27. Биобэлдмэл		
28. Хэрлэн		
29. Медпланта		
30. Түшиглэн		
31. Фигофарм		
32. Аюувэд		
33. Даривфарм		
34. Монхимо		
35. Шинэ эхлэл		
36. Монмедтех		
37. Жи Жи Монгол Сино Же Женг		
38. Мерит		

Хавсралт -2

- I –Орчин үеийн буюу Европ эмийн үйлдвэр-24
- II –Уламжлалт эмийн үйлдвэр-6
- III –Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр-3
- IV –Цус, биобэлдмэлийн үйлдвэр-4
- V –Ариутгал, халдваргүйжилтийн үйлдвэр-1

Ном зүй

1. Ням-Осор.Д Аптечному делу МНР-40 лет, Аптечное дело, М, 1964, №3, с.78
2. Содномдаржаа.Г БНМАУ-ын эм хангамж 60 жилд
3. Туваан.Г Сорок лет Народного здравоохранения МНР. Архив МЗ МНР, фонд 22, информац. Сообщение МЗ МНР, УБ 1965 №2, с. 6-24
4. Цагаанхүү.Д Здравоохранения МНР в 1919-1960 гг. Дисс. На соискание ученой степени канд. Мед. Наук, М. 1963, 307 с
5. Монгол улсад эм хангамжийн алба үүсч хөгжсөний 80 жил /Илтгэлийн хураангуй УБ-2003 х-5/
6. Эмийн үйлдвэрлэл, хангамж үйлчилгээний лавлах УБ 1999, 2005 х-3-10

7. Эм хангамжийн хөгжлийн төлөө хамтдаа /Их хурлын илтгэлийн материал УБ 2006, х-20-23/
8. Л.Хүрэлбаатар Эм хангамжийн хөгжлийн чиг хандлага УБ 2006, х-6-10
9. Р.Бямбаа, Д.Ням-Осор Монгол улсын эм хангамжийн хөгжил 80 жилд Монголын анагаах ухаан сэтгүүл УБ 2005, х-20-25
10. Монгол уламжлалт эмийн зах зээлийн судалгааны тайлан УБ 2007, х-10-17
11. Эмийн үйлдвэр ХХК-ний болон “Эм” холбооны архивын материал